



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/39

Дэлгэрхаан сум

**Бүх нийтийн их цэвэрлэгээ зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5.2 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.2.10 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сумын төвийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хаврын бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 04 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд нийтийн эзэмшлийн газар, тоглоомын талбай, хайс хашаа, хогийн сав, аж ахуйн нэгж байгууллагуудын гадна талбай, хуваарьт газрын хогийг цэвэрлэх ажлыг зохион байгуулсугай.

2. Бүх нийтийн их цэвэрлэгээнд хяналт тавих, зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, цэвэрлэгээг хамтран оролцох зохион байгуулах төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар, шаардагдах шатахууны зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, их цэвэрлэгээний ажилд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг өргөнөөр татан оролцуулахыг багийн Засаг дарга нарт, хог хаягдлын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх, цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг ачиж тээвэрлэх ажлыг зохион байгуулахыг "Дэлгэрхаан сумын аварга тохижилт" аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирал (Э.Сумъяа), их цэвэрлэгээний ажилд иргэд олон нийтийг татан оролцуулах, уриалга гарган зар хүргэх ажлыг хариуцан хэрэгжүүлэхийг байгаль хамгаалагч (Х.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

4. Их цэвэрлэгээ зохион байгуулахад шаардагдах шатахууны зардалд 163,000 (нэг зуун жаран гурван мянга) төгрөгийг хог хаягдлын зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Урангоо), нягтлан бсдогч (О.Анхцэцэг) нарт зөвшөөрсүгэй.


5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Батнасан)-д даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН


Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын 01-ны
өдрийн 132 дугаар захирамжийн 1 хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн дарга:	Д.Батнасан	Засаг даргын орлогч
Гишүүд:	Д.Урангоо	Засаг даргын Тамгын газрын дарга
	Н.Цэнддолжин	2-р багийн Засаг дарга
	Б.Мөнхболд	3-р багийн Засаг дарга
	Д.Оюунчимэг	4-р багийн Засаг дарга
	Г.Батнасан	5-р багийн Засаг дарга
	Д.Баярмаа	Тархвар зүйч
	Х.Мөнхбат	Байгаль хамгаалагч
	П.Ангараг	Цаг уурын харуул
	Э.Сумъяа	Дэлгэрхаан аварга аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар
	Ш.Цэрэндулам	Ерөнхий боловсролын сургуулийн захирал
	С.Эрдэнэсүвд	Хүүхдийн цэцэрлэг
	Н.Доржнамжил	Соёлын төв
	О.Батбаяр	Эрүүл мэндийн төв
	Бат-Очир	Зэвсэгт хүчний 232-р анги
	Д.Шижирхүү	Хөдөө арлын цагаан нуур ХХК
	С.Ганхуяг	Мөнгөн бадрал ХХК
	Ц.Оюун-Эрдэнэ	Дэлгэрхангай ХХК
	Д.Цэрэнбуян	Энхдүүрэн баян ХХК

Засаг даргын 2015 оны 02 дугаар сарын 01-ны
өдрийн 4/9 дугаар захирамжийн 2 хавсралт



ЦЭВЭРЛЭГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Гудамж, зам талбай, голын ай сав газар, айл өрх аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлын ачилт, тээвэрлэлтийн ажлыг эрчимжүүлэх	04.01-04.15	Байгаль хамгаалагч, багийн дарга нар, ААНэгжүүд, АБайгууллагын дарга нар ОНӨААТҮГ
2	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд байгаа нүхэн жорлонг буулгах	04.01-04.15	Байгаль хамгаалагч, ОНӨААТҮГ
3	Цэцэрлэгт хүрээлэн, наадмын талбай, морь барианы талбайн хог цэвэрлэгээг хийлгэх	04.01-04.15	ОНӨААТҮГ (Э.Сумъяа),
4	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадна орчныг угааж цэвэрлэх	04.01-04.15	ЕБСургуулийн захиргаа, СӨБ
5	Нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн шонг засварлах, шатсан гэрлүүдийг солих, унасан шонг татан авах	04.01-04.15	Аварга багийн дарга, ЗДТГазрын нярав, Монтчёр
6	Хийгдэж байгаа ажлын явцын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудыг сурталчлах	04.01-04.15	Аварга багийн дарга, Хэвлэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
7	Нийтийн эзэмшлийн талбайг ААНэгж, АБайгууллагууд хувиарлсан талбайг цэвэрлэх	04.01-04.15	ААНэгж, АБайгууллгын ажилчид
8	Зөвшөөрөлгүй газар хог хаягдал хаясан тохиолдолд зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ тооцох	Тухай бүр	БОХУБайцаагч

Засаг даргын 20.45-оны 04 дугаар сарын 01-ны
өдрийн 1/38 дугаар захирамжийн 3 хавсралт



ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ЗАРДАЛ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Литр	нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Дт	л	50	3260	163,000
	Дүн	163,000			



مجلس السكس من مجلس السكس

०१२३४५६७८९

3/12/20

10/10/2020

[illegible][illegible]

میں نے ان کے لئے ایک اور چیز کی ضرورت محسوس کی۔ ان کے لئے ایک ایسا ایجنڈا بنانا جس سے ان کی زندگی میں ایک نیا رنگ پڑے۔ ان کے لئے ایک ایسا ایجنڈا بنانا جس سے ان کی زندگی میں ایک نیا رنگ پڑے۔

[illegible][illegible][illegible][illegible][illegible]